



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 12 сарын 21 өдөр

Дугаар А/819

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 –ийн “л” заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 10/06 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1.Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдсан “Жаргалант агро парк” төслийн ажлыг өмч бүртгэлд шилжүүлэх хүртэлх хугацаанд сахиулаар ажиллаж буй Цэвээний Эрдэнэчулууны 9, 10, 11, 12 дугаар саруудын урамшуулал болох нийт 1.400.000 /нэг сая дөрвөн зуун мянган/ төгрөгийг “Хүлэмжийн аж ахуйг хөгжүүлэх” дэд хөтөлбөрөөс зарцуулахыг зөвшөөрсүгэй.

2.Орон нутгийн хөгжлийн сангийн 5.3 дахь заалтад тусгагдсан “Хүлэмжийн аж ахуйг хөгжүүлэх” хөтөлбөрөөс 1,400.000 /нэг сая дөрвөн зуун мянган/ төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлж санхүүжүүлж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга /Б.Баярсүх/ нарт зөвшөөрсүгэй.

3.Уг арга хэмжээнд хяналт тавьж сахиулыг арга зүйн зөвлөгөөгөөр хангаж, тайлагнаж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга /Б.Бямбажав/-д үүрэг болгосугай.

4.Энэхүү захирамжийн хэрэгжилтийг ханган ажиллахыг Засаг даргын орлогч /Г.Жаргалсайхан/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Zax A/819 Ch

02 4109